

ДОТООДЫН ЗӨВЛӨХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРИЛГА

Огноо: 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Зорилго: Хууль тогтоомж, эрх зүйн актыг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд тухайн эрх зүйн актад жендэрийн үзэл баримтлал туссан эсэхийг үнэлэх шалгуур үзүүлэлт болон түүнийг хэрхэн хэрэглэх аргачлал боловсруулж, турших

Захиалагч: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүн амын сан

Зөвлөхийн гүйцэтгэх ажил:

1. Дараах чиглэлээр дүн шинжилгээ хийж, хууль тогтоомж, эрх зүйн актыг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд тухайн эрх зүйн актад жендэрийн үзэл баримтлал туссан эсэхийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хэрэглэгдэхүүн болон түүнийг хэрхэн хэрэглэх аргачлалыг боловсруулна.

➤ Хууль тогтоомж, эрх зүйн актыг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд тухайн эрх зүйн актад жендэрийн үзэл баримтлал туссан эсэхийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хэрэглэгдэхүүн жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцооны хүрээнд байгаа эсэхийг судалж, үнэлгээ хийх,

➤ Хууль тогтоомж, эрх зүйн актыг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд тухайн эрх зүйн актад жендэрийн үзэл баримтлал туссан эсэхийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хэрэглэгдэхүүн болон түүнийг хэрхэн хэрэглэх аргачлалыг холбогдох олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон тэдгээрийг дагалдан гарсан Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэр, дүрэм, журамд нийцүүлэн шинээр боловсруулж; холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаар хэлэлцүүлэх,

2. Боловсруулсан шалгуур үзүүлэлт, хэрэглэгдэхүүнийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд туршиж, тус хуульд жендэрийн үзэл баримтлал тусгагдсан эсэх талаар дүн шинжилгээний тайлан боловсруулах;

Хугацаа: 2 сар

Нийлүүлэх бүтээгдэхүүн:

1. Хууль тогтоомж, эрх зүйн актыг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд тухайн эрх зүйн актад жендэрийн үзэл баримтлал туссан эсэхийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хэрэглэгдэхүүн

2. Дээрх шалгуур үзүүлэлт, хэрэглэгдэхүүнийг хэрхэн хэрэглэх аргачлал

3. Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаар хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийн тайлан, саналын нэгтгэл /хэлэлцүүлэг бүрээр/

4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд жендэрийн үзэл баримтлал тусгагдсан эсэх талаарх дүн шинжилгээний тайлан

Зөвлөхөд тавигдах шаардлага:

- Боловсрол: Дээд, хууль эрх зүй, нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй.
- Туршлага: Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан. ижил төрлийн төсөл дээр ажиллаж байсан туршлагатай, жөндөр болон, жөндөрт суурилсан хүчирхийлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ мониторингийн чиглэлээр ажиллаж байсан бол давуу тал болно.
- Мэргэжлийн ур чадвар:
 - Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, нийгмийн бусад харилцааны талаар өргөн хүрээний мэдлэгтэй, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэлт хийх чадвартай байх
 - Хүний эрхийн асуудлууд, түүний дотор жөндөрийн тэгш байдал, жөндөрт суурилсан хүчирхийллийн асуудлаар өргөн мэдлэг, эерэг хандлагатай байх
 - Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, удирдан чиглүүлэх чадвартай байх
 - Асуудал, баримт бичиг боловсруулах, дүн шинжилгээ хийх чадвартай байх
 - Богино хугацаанд ачаалалтай бие даан болон бусадтай хамтран ажиллах, хувийн зохион байгуулалт сайтай байх
 - Холбогдох салбартаа ашиг сонирхлын зөрчилгүй байх

Бүрдүүлэх материал:

1. Уг ажлыг гүйцэтгэх хүсэл сонирхлоо илэрхийлсэн хүсэлт
2. Анкет
3. Мэргэжил, мэргэшил, мэдлэгийг нотлох баримт, үүнд: диплом, сертификат, гэрчилгээний хуулбар
4. Бүтээлийн жагсаалт
5. Ажлын санал /төлөвлөгөө, гүйцэтгэх арга/

Сонирхсон этгээд дээр дурдсан материалыг цаасан хэлбэрээр бүрдүүлэн битүүмжилж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 202 тоот өрөөнд **2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 17:30 цагаас** өмнө биечлэн авчирч өгнө үү.

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, НҮБ-ын гудамж, Засгийн газрын II байр, ХНХЯамны 2 давхарт 202 тоот өрөө, Утас 51-261569